




БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧ ЁС ЗҮЙН ДҮРЭМ



1	ОРШИЛ.....	3
1.1	Олон улсын хамрах хүрээ	3
1.2	Удирдлагын систем	3
1.3	Хэрэгжүүлэх ба дагаж мөрдөх	4
1.4	Хяналт.....	4
2	ХУУЛЬ ЁСЫГ ДАГАЖ МӨРДӨХ.....	5
3	ЭРҮҮЛ МЭНД БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ	6
4	ХҮНИЙ БА ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХҮҮД.....	7
4.1	Хүний эрхийн магадлан шалгах	7
4.2	Хүүхдийн хөдөлмөр	7
4.3	Орчин үеийн боолчлол	8
4.4	Ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, хатуу ширүүн эсвэл хүнлэг бусаар хандах.....	9
4.5	Ажлын цаг болон нөхөн олговор	10
4.6	Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон хамтын хэлэлцээр	11
4.7	Газар нутаг болон нөөц баялаг эзэмших, үл хөдлөх хөрөнгө ашиглах	12
5	АШИГТ МАЛТМАЛ БА МЕТАЛИЙГ ХАРИУЦЛАГАТАЙГААР ОЛЖ АВАХ.....	13
6	ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН	14
7	БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ	15
7.1	Авилгын эсрэг	15
7.2	Өрсөлдөөний хууль	15
7.3	Хувийн мэдээллийн сангийн хамгаалалт.....	16
7.4	Арилжааны дүрэм журмыг дагаж мөрдөх.....	16
	БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛ.....	17

1 ОРШИЛ

Сэндвик нь одоо ба ирээдүй хойч үеийн төлөөх тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах үүрэг амлалт хүлээсэн. Үүнд, бидний үйл ажиллагаа ба ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээнд нөлөөлж буй хүрээлэн буй орчин, хүний эрх ба засаглалын сөрөг нөлөөг таниулах, сэргийлэх, бууруулах болон таслан зогсоох багтана.

Бид өөрсдийн эдийн засаг, хүрээлэн буй орчин болон нийгмийн үйл ажиллагааны дэлхий ертөнцөд үзүүлж буй нөлөөлөлд хариуцлага хүлээдэг. Улмаар, Сэндвик нь биднийг энэхүү үүрэг хариуцлагад хөтлөх зорилгоор Тогтвортой Байдлын Зорилтууд, Сэндвик Компанийн Ёс Зүйн Дүрэм болон Бэлтгэн Нийлүүлэгчийн Дүрмийг (цаашид “Ханган Нийлүүлэгчийн Дүрэм” гэх) гаргасан билээ. Бэлтгэн нийлүүлэгчийн дүрэм нь (цаашид “нийлүүлэгч” гэх) манай бэлтгэн нийлүүлэгчид болон үйлчилгээ үзүүлэгчдэд хамаарна.

Бид өөрсдийн нийлүүлэгчдээс Бэлтгэн Нийлүүлэгчийн Дүрмийг дагаж мөрдөхийн зэрэгцээ Сэндвикийн Тогтвортой Байдлын Зорилтуудад хувь нэмэр оруулах үүднээс бидэнтэй хамтран ажиллахад нээлттэй байгаасаа гэж хүсдэг.

- Бид тогтвортой байдлыг бий болгодог
- Бид уур амьсгалыг хамгаалдаг
- Бид хүмүүсийг нэн тэргүүнд тавьдаг
- Бид шударгаар тоглодог



1.1 ОЛОН УЛСЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Бид НҮБ-ын Хүний эрхийн олон улсын суурь гэрээ, Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын ажлын байран дээрх суурь зарчим ба Хүний эрхүүдийн талаарх Тунхаглал, Хүрээлэн буй орчин, Хөгжлийн тухай Риогийн тунхаглал болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Глобал компакт буюу Даян дэлхийн гэрээний арван зарчимд тусгагдсан Авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний Байгууллагын Конвенцыг дэмждэг.

Бид эдгээр зарчмууд болон ЭЗХАХБ-ын (OECD) Үндэстэн дамнасан компанийн удирдамж, НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийг удирдах зарчмуудыг даган мөрдөх үүрэг хүлээсэн бөгөөд өөрсдийн бэлтгэн нийлүүлэгчдээс ч мөн бас хүсдэг.

1.2 УДИРДЛАГЫН СИСТЕМ

Өөрсдийн нийлүүлэгчдээ тасралтгүй сайжран ажиллахын зэрэгцээ бэлтгэн нийлүүлэгчийн ёс зүйн дүрэмд тусгагдсан удирдлагын систем, стандартуудыг бий болгох, хэрэгжүүлэх, цаашид авч явахыг бид уриалдаг. Эрсдлийн үнэлгээ, хэрэгжүүлж байгаа бодлого, тогтсон дэг журам, тодорхой тайлбарласан үүрэг, хариуцлагууд, түүнтэй холбогдох сургалт, зааварчилгаа, хэмжигдэх боломжтой зорилтуудыг бий болгох, үнэлэх хяналтын системийн тусламжтайгаар бэлтгэн нийлүүлэгчийн дүрмийг амжилттай хэрэгжүүлэх үндэс тавигддаг.

Ажилтнууд нь хууль ёсны шаардлага эсвэл компанийн бодлого/дүрмүүдийг дагаж мөрдөхтэй холбоотой урган гарсан асуудлуудыг өөрсдийн ажил олгогчид заналхийлэлд өртөх байх гэсэн айдасгүйгээр мэдэгдэх эрхтэй байх ёстой.

1.3 ХЭРЭГЖҮҮЛЭХ БА ДАГАЖ МӨРДӨХ

Сэндвик нь нийлүүлэгчийг бэлтгэн нийлүүлэгчийн дүрмийг даган мөрдөж буй эсэхэд үнэлгээ өгөхдөө тухайн харилцагчийн эрхэлж буй бизнесийн мөн чанар болон түүнд тулгарах эрсдлүүдийг харгалзан үзнэ.

Бэлтгэн нийлүүлэгчид тусгайлан тавигдах тогтвортой байдлын шаардлага ба зорилтуудыг арилжааны гэрээнд тусгаж болно.

Нийлүүлэгч нь бэлтгэн нийлүүлэгчийн дүрмийг дагаж буй эсэхийг баталгаажуулах эсвэл хууль дүрмийг мөрдөхгүй байгааг илрүүлсэн тохиолдолд тодорхой хугацаанд арга хэмжээ авах эрхийг Сэндвик компанид олгохоос татгалзсан нөхцөлд уг дүрмийг зөрчсөн гэж үзэж болно. Үүнээс үүдэн тухайн бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээгээ дуусгавар болгох эрхтэй.

Бэлтгэн нийлүүлэгчийн дүрэм нь дараах бүтэцтэй байна:

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Бэлтгэн нийлүүлэгчийн дүрэмд тусгасан шаардлагуудыг өөрсдийн байгууллага болон өөрийн ханган нийлүүлэлтийн сүлжээнд нэвтрүүлэх үүрэгтэй.

ЗААВАРЧИЛГАА

Шаардлагуудыг хэрхэн биелүүлэх тухай жишээнүүд.

БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Шаардлагуудыг дагаж мөрдөж буйг нотлох жишээнүүд, эсвэл өөр ямар ч нотолгоог хүлээн зөвшөөрнө.

1.4 ХЯНАЛТ

Сэндвик болон түүний нийлүүлэгчдийн хоорондын бизнесийн бүх харилцаа шударга байдал, итгэлцэл мөн хамтын ажиллагаан дээр тулгуурлах ёстой. Бэлтгэн нийлүүлэгчийн дүрмийг хүлээн зөвшөөрснөөр, нийлүүлэгч нь эдгээр шаардлагуудыг өөрийн үйл ажиллагаа болон өөрийн харилцагчийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх үүрэг хүлээдэг. Сэндвик компанид ил тод байдлаар хамтран ажиллах замаар үүнд хүрэх боломжтой бөгөөд бэлтгэн нийлүүлэгч нь шаардсан тохиолдолд шаардлагуудыг хэрхэн дагаж мөрдөж буйгаа харуулах ёстой. Сэндвик нь харилцан яриа, өөрийгөө үнэлэх санал асуулга өрнүүлэх эсвэл нийлүүлэгчийн ажлын талбай дээр аудитын шалгалт хийх замаар уг дүрмийг дагаж мөрдөж байгаа эсэхийг баталгаажуулж болно. Үүнд, ажилтнуудтай ярилцлага хийх болон бэлтгэн нийлүүлэгчийн дүрэмтэй холбоотой бичиг баримт, бүртгэлийг харах зөвшөөрөл багтана. Бэлтгэн нийлүүлэгчийн туслах гүйцэтгэгч дээр хийгдэх аливаа аудит эсвэл үзлэг шалгалтыг тухайн нийлүүлэгчтэй зөвшилцсөний үндсэн дээр гүйцэтгэнэ. Дүрмийг дагаж мөрдөж буй эсэхийг Сэндвик компанийн ажилтнууд эсвэл Сэндвик компаниас томилогдсон бие даасан гуравдагч этгээд шалгана.

Нийлүүлэгчид өөрсдийн харилцагчдыг бэлтгэн нийлүүлэгчийн дүрмийн шаардлагууд эсвэл түүнтэй адилтгах шаардлагуудыг дагаж мөрдөж буй эсэхэд хяналт тавих ба өөрийн худалдан авалтын үйл ажиллагаанд дээрх дүрмүүдийг мөрдлөг болгож буй эсэхэд хяналт тавих, үнэлэх үүрэгтэй.

Та бэлтгэн нийлүүлэгчийн дүрэм эсвэл хууль тогтоомжуудыг дагаж мөрдөхгүй байгаа мэт харагдах нөхцөл байдлуудтай тулгарч болно. Ийм тохиолдолд бид таныг аль болох хурдан Сэндвик компанид мэдэгдэхийг хүсч байгаа бөгөөд ингэснээр бид энэ асуудлыг шийдвэрлэж, ёс зүйтэй, тогтвортой компани хэвээр үлдэх боломжтой болно. Бэлтгэн нийлүүлэгчийн дүрмийн зөрчлийг Сэндвик компанийн хүн эсвэл Sandvik.com дээрх манай Speak Up системээр дамжуулан Сэндвик компанид мэдэгдэх шаардлагатай.

Сэндвик нь хүлээн авсан бизнесийн болон хувийн бүх мэдээлэлдээ хариуцлагатай ханддаг бөгөөд энэхүү мэдээллийн нууцлалыг хадгалах арга хэмжээг авдаг.

2 ХУУЛЬ ЁСЫГ ДАГАЖ МӨРДӨХ



Холбогдох хууль зүйн шаардлагуудын талаар мэдэж, хэрэгжүүлж байхад хяналт тавих нь бэлтгэн нийлүүлэгчийн дүрмийг дагаж мөрдөх суурь үндэс болж өгдөг.

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Нийлүүлэгчид нь байнга мэдээлэлтэй байж, үндэсний болон бүсийн хууль тогтоомж, түүнчлэн бэлтгэн нийлүүлэгчийн дүрмийн зүйл заалтуудтай холбоотой олон улсын холбогдох зохицуулалт, конвенцуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Бэлтгэн нийлүүлэгчид нь дотоодын аливаа зохицуулалт, түүний хэрэгжилт нь олон улсын хүний эрхийн стандартуудтай зөрчилдөж буй эсэх талаар ойлголттой байж, даян дэлхийд танигдсан хүний эрхийг дээдлэх үйлсийг түгээх эрмэлзлэлтэй байх ёстой.

Бэлтгэн нийлүүлэгчийн дүрэм орон нутгийн хууль тогтоомжоос илүү чанга байх нөхцөлд уг дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх шаардлагатай. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, зохицуулалтуудын хооронд бодит эсвэл болзошгүй зөрчил үүссэн тохиолдолд бэлтгэн нийлүүлэгчид Сэндвик компанид мэдэгдэх шаардлагатай.

ЗААВАРЧИЛГАА

Тухайн бизнестэй холбоотой хууль зүйн шаардлагуудын талаар мэдээлэлтэй байж, тэдгээрийг хэрэгжүүлэх, шинэчлэгдсэн өөрчлөлтийн талаар мэдлэгтэй байгаарай.


Хуулиар шаардсан бүх зөвшөөрөл, лиценз болон бүртгэлүүдийг олж авч, тэдгээрийг хүчинтэй байлгахад анхаараарай.

БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Бид доорх хэсгүүдэд хууль дүрмийг хэрхэн дагаж мөрдөж буй талаар таниас асуух болно:

- эрүүл мэнд ба аюулгүй байдал
- хүний эрх
- хөдөлмөрлөх эрх
- ажиллах орчин нөхцөл
- хүрээлэн буй орчин
- татвар
- авилгын эсрэг арга хэмжээнүүд
- гааль, экспортын хяналт
- өгөгдлийн сангийн нууцлал
- ашигт малтмал, металыг хариуцлагатайгаар олж авах

3 ЭРҮҮЛ МЭНД БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Хүмүүст хор хөнөөлгүй уриа нь Сэндвик компаний үйл ажиллагааны суурь зарчим юм.

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Бэлтгэн нийлүүлэгчид нь аюулгүй, эрүүл ажиллах орчин нөхцөлөөр хангаж, осол, гэмтэл бэртлээс сэргийлэх бүх бодит арга хэмжээг авах үүрэгтэй.

Бэлтгэн нийлүүлэгч нь бүх ажилтнуудаа энгийн зааварчилгаа, сургалтаар хангахын зэрэгцээ эрсдэлд суурилсан эрүүл мэнд, аюулгүй байдлын арга хэмжээг хангалттай хэмжээнд авах ёстой.

Ажлын нөхцөл байдал нь ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулж байна гэж үзэх үндэслэлтэй шалтгаан байгаа бол ажил гүйцэтгэхээс татгалзах эрхээр хангагдах ёстой.

Ажилчдын сууц, хоолны газар зэргийг багтаасан байгууламжийн галын аюулгүй байдал, ариун цэврийн стандартуудыг хангаж буй эсэхэд өдөр тутам, тогтмол үзлэг шалгалт явуулах ёстой.

Хэрэв оршин суух сууцаар хангаж буй бол ажилтнууд нь өөрийн гэсэн унтах ор, хүйсээр тусгаарлагдсан унтлагын хэсгээр хангагдах ёстой.

ЗААВАРЧИЛГАА

Тухайн бизнесийн үйл ажиллагаанд эрүүл мэнд, аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээг тогтмол хийж, урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээг үнэлээрэй.


БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Зайлшгүй байх зүйлс:

- Барилгуудыг үйл ажиллагааны зөвшөөрлөөр баталгаажуулсан зориулалтынх нь дагуу ашиглана.
- Цахилгааны шугам кабел, гэрэлтүүлэг болон хийн төхөөрөмжийг зөв суурилуулж, ашиглах.
- Галын дохиоллын ажиллагаа, гал унтраах тоног төхөөрөмжийн хүрэлцээ, нүүлгэн шилжүүлэх замыг тодорхой тэмдэглэж, ашиглах боломжтой байх, онцгой байдлын үед ашиглах гарцыг тухайн байгууламжийн хэмжээнд тулгуурлан гаргах.
- Гал түймрийн болон нүүлгэн шилжүүлэх сургалтыг тогтмол явуулах.
- Онцгой байдлын төлөвлөгөө болон хариу арга хэмжээний гүйцэтгэл
- Эрүүл мэнд ба аюулгүй байдалд хөнөөл учруулах зүйлсийг бууруулах хяналтын арга хэмжээнүүдийг хангалттай авах.
- Ажлын байрны гэмтэл бэртэл, өвчлөлийг зохицуулах, хянах ба мэдээлэх үйл явц, системүүдийг хэрэгжүүлэх.
- Ажилтнууд цэвэрхэн, үнэ төлбөргүй, ажил үүрэгт тохирох хувийн хамгаалах хэрэгсэл, хамгаалалтын хувцас ашиглах.
- Шаардлагатай анхны тусламжийн хэрэгслүүдийг хялбархан ашиглах боломжтой байх, ажилтнууд анхны тусламжийн сургалтанд хамрагдсан байх.
- Ажилтнуудыг мансууруулах бодис эсвэл согтууруулах ундааны нөлөөллийн дор ажиллуулахгүй байх.
- Ажлын байр нь цэвэрхэн, гэрэлтүүлэг сайтай, хангалттай агааржуулалттай, тохиромжтой температурт, тохиромжтой дуу чимээний түвшинтэй байх.
- Ундны цэвэр усыг үнэ төлбөргүй хүртэж, хоол идэх цэвэр орчин, ариун цэврийн шаардлагыг хангасан бие засах газруудтай байхын зэрэгцээ боломжтой бол шүршүүрээр хангах.

4 ХҮНИЙ БА ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХҮҮД

Хүний болон хөдөлмөрлөх эрхүүдийг хүндэтгэх нь Сэндвик компаний давуу тал. Үүнд, ажилтнуудад нэр хүндтэй, хүндэтгэлтэй, шударга хандахын сацуу, хүний болон хөдөлмөрлөх эрхийн зөрчлийг үүсгэх аливаа үйлдлээс зайлсхийх багтана.



4.1 ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШАЛГАХ

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Бэлтгэн нийлүүлэгчид нь өөрсдийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээнд шууд ба шууд бус холбоотой хүний эрхийн аливаа нөлөөллүүдийн талаар ойлголттой байж, анхаарлаа хандуулах ёстой.

ЗААВАРЧИЛГАА

Хүний эрхэд үзүүлж буй бизнесийн үйл ажиллагааны нөлөөллийг таниулах, сэргийлэх, бууруулах болон арилгах зорилгоор хүний эрхийг магадлан шалгах замаар хүний эрхийг бэхжүүлээрэй.

БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Зайлшгүй байх зүйлс:

- Хүний эрхийн магадлан шалгалтын үр дүнг хянах.

4.2 ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Сэндвик компани нь хүүхдээр хөдөлмөр эрхлүүлэхийг хүлээн зөвшөөрдөггүй. Нийлүүлэгчид, өөрсдийн үйл ажиллагаа болон бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээндээ хүүхдээр хөдөлмөр эрхлүүлэхээс зайлсхийж, залуу ажилтнуудад хууль ёсны дагуу ажиллах нөхцөлийг хангах үүрэгтэй.

Хэрэв хүүхдээр хөдөлмөр эрхлүүлж буй нь илэрсэн бол тухайн хүүхдийн туйлын ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.

Ажилтнууд нь 15-аас доош насны (эсвэл үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрсөн нөхцөлд 14) эсвэл дотоодын хууль тогтоомжоор хөдөлмөрийн насны доод хэмжээг өндрөөр тогтоосон нөхцөлд түүнээс доош насны байж болохгүй.

Залуу ажилтнууд (18 наснаас доош) оюун санаа, бие махбодь, нийгмийн эсвэл ёс суртахууны хувьд хөнөөлтэй эсвэл тэдний заавал судлах хичээлд саад болохуйц ажлыг гүйцэтгэх ёсгүй. Залуу ажилтнууд шөнийн ээлжинд ажиллах ёсгүй.

ЗААВАРЧИЛГАА

Тухайлбал, нас баталгаажуулах бичиг баримтын хуулбар зэрэг, бүх ажилтнуудын хөдөлмөр эрхлэх хууль ёсны насны бүртгэлийг хадгалаарай.

БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Зайлшгүй байх зүйлс:

- Бүх ажлуудыг хөдөлмөр эрхлэх хууль ёсны насанд хүрсэн ажилтнуудаар гүйцэтгүүлэх.
- Насанд хүрээгүй ажилчдыг ажилд авахгүй байхыг баталгаажуулах системтэй байх.
- Залуу ажилтнуудыг хууль ёсны ажиллах орчин нөхцлөөр хангах.

4.3 ОРЧИН ҮЕИЙН БООЛЧЛОЛ

Сэндвик компани нь албадлага, хүчилж эсвэл шахалтаар хөдөлмөр эрхлүүлэх, боолчлох, төөрөгдүүлж ажилд авах, угсаа гарал дээр суурилсан боолчлол, хүний наймаа зэргийг багтаасан орчин үеийн боолчлолыг хүлээн зөвшөөрдөггүй. Үүнд албан шахалтаар хийгдсэн бүх ажил хамаарахаас гадна албадлага, оюун санааны болон/эсвэл бие махбодийн заналхийлэл, дарамт үзүүлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, төөрөгдүүлэн мэхлэх зэрэг хамаарна.

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Бэлтгэн нийлүүлэгчид болон тэдний хөдөлмөр зуучийн агентууд дараах зүйлсэд оролцож эсвэл хүлцэн тэсвэрлэж болохгүй:

- хөдөлгөөнийг хязгаарлах
- хөдөлмөр зуучийн хэт өндөр хураамж эсвэл бэлэн мөнгөний барьцаа
- биеийн байцаалтын бичиг баримт ба/эсвэл паспортуудыг хураан авах
- цалин хөлсөөс суутгах
- хөдөлмөрийн нөхцлийг зөрчсөн ажиллах орчин
- цалин хөлсийг өр төлбөрөөс суутгах
- хүчирхийлэл

эсвэл хүний наймаа, шоронгийн хоригдлуудаар хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийн боолчлол, албадлагын хөдөлмөр зэрэг албадсан, хүчилсэн, хууль бус аливаа хөдөлмөр эрхлэлт эсвэл мөлжлөг, дарангуйллын аливаа бусад төрөл.

ЗААВАРЧИЛГАА

Салбар дахь орчин үеийн боолчлолын эрсдлүүдийн талаар ойлголттой байж, орчин үеийн боолчлолд тэг хүлцэл бүхий урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлээрэй.

Бэлтгэн нийлүүлэгчид, гэрээлэгчид болон туслах гэрээлэгчдэд хэт их ачаалал өгөх эсвэл орчин үеийн боолчлолд хөтлөх магадлалтай бизнесийн арга ажиллагаа, шийдвэрүүдээс зайлсхийгээрэй.

БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Зайлшгүй байх зүйлс:

- Орон нутгийн хууль тогтоомжийн дагуу зайлшгүй шаардлагатай гэж үзсэнээс бусад тохиолдолд илүү цагаар ажиллахын тулд харилцан тохиролцсон байх.
- Ажилтнууд амрах цагаараа өөрсдийн орон байр болон ажлын байрыг чөлөөтэй орхиж явах эрхтэй байх.
- Ажилтнуудаас засгийн газрын олгосон үнэмлэх, паспорт, ажиллах зөвшөөрөл зэрэг хувийн гэрчилгээ, үнэмлэхийн эх хувийг ажил эрхлэх нөхцөл болгож хураалгахыг шаардахгүй байх.
- Цалин хөлснөөс шударга бус эсвэл хууль бус суутгал авах, цалин хөлсөөс суутгах зэрэг хууль бус сахилгын арга хэмжээ эсвэл санхүүгийн торгуулийн аргыг ашиглахгүй байх, сахилгын арга хэмжээ болгож тэтгэмжийг зогсоохгүй байх.
- Ажилтнуудыг зохих журмын дагуу мэдэгдэл өгч, ажлаасаа гарахад саад болох барьцаа, хураамж, торгууль, зээл эсвэл төлбөр төлөлтийн гэрээ байгуулахгүй байх.
- Төлбөр төлөлтийн гэрээнүүд нь урьдчилан харж болох, зүй ёсны бөгөөд цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байх.
- Цагаач ажилчдад дотоодын ажилтнуудтай адил тэгш, шударга хандах.

4.4 ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ, ХҮЧИРХИЙЛЭЛ, ХАТУУ ШИРҮҮН ЭСВЭЛ ХҮНЛЭГ БУСААР ХАНДАХ

Сэндвик компани ажлын байрны ялгаварлан гадуурхалтыг хүлээн зөвшөөрдөггүй. Олон соёлт ажилтнуудаас бүрдсэн багууд нь компанийн гүйцэтгэл болон үр дүнг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Бэлтгэн нийлүүлэгч ажилтан бүрийнхээ хувийн нэр төр, нууцлал болон эрхийг хүндэтгэх ёстой бөгөөд бие махбодийн эсвэл аман, аман бус хэлбэрээр илэрхийлсэн оюун санааны аливаа хүчирхийлэл, дарамт шахалтыг тэвчих ёсгүй.

Бэлтгэн нийлүүлэгчид нь бэлгийн дарамт, албадлагын, заналхийлсэн, дарамталсан эсвэл мөлжлөгийн шинжтэй зан авир гаргах, үг хэллэг ашиглах болон биет байдлаар хүрэлцэхийг хориглох ёстой.

Бэлтгэн нийлүүлэгч нь ажилд авахдаа нас, иргэншил, үндэс угсаа, шашин шүтлэг, улс төрийн итгэл үнэмшил, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа эсвэл илэрхийлэл, бие махбодийн чадвар эсвэл Олон Улсын Хүний Эрхийн Байгууллагын (ILO) Конвенцууд, хууль тогтоомжоор хамгаалагдсан аливаа бусад хэв шинж дээр суурилан идэвхтэй, идэвхгүй байдлаар шударга бусаар ялгаварлан гадуурхах ёсгүй.

Бэлтгэн нийлүүлэгчид нь олон нийтийн анхааруулга болон шийтгэлийн системийг хориглох ёстой.

ЗААВАРЧИЛГАА

Ялгаварлан гадуурхалтаас ангид ажлын байрны соёлыг бий болгоорой.

Хүмүүст хувь нэмрээ оруулах, хүчээ сориход нь аюулгүй санагддаг олон соёлт ажилтнуудаас бүрдсэн багууд болон ажлын орчныг хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргаарай.

БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БҮЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Зайлшгүй байх зүйлс:

- Ажилд авах, урамшуулал олгох, ажил эрхлэлт, ялгаварлан гадуурхахаас ангид байх болон тэгш боломж олгох талаарх арга ажиллагаануудыг хэрэгжүүлж, бий болгох.
- Ялгаварлан гадуурхсан, дарамталсан зан авирыг заналхийлэлд өртөлгүйгээр мэдээлэх, мөрдөн шалгах болон хориг тавих боломж олгох бүтцийг бий болгох.

4.5 АЖЛЫН ЦАГ БОЛОН НӨХӨН ОЛГОВОР

Ажиллах зохистой орчин нөхцлөөр хангахад зохистой ажлын цаг болон урамшууллын тэгш систем хамгийн чухал. Хангалттай амрааж, ажлаас чөлөө олгож байх нь ажлын байран дахь гэмтэл бэртлээс сэргийлж, бүтээмжийг сайжруулдаг.

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Ажлын цаг, илүү цаг, амралт болон чөлөөнүүд нь холбогдох хууль зүйн шаардлагууд эсвэл холбогдох хамтын гэрээг дагаж мөрдөх ёстой.

Хэт их илүү цагаар ажиллуулах нь энгийн асуудал байх ёсгүй.

Ажилтнуудад хамаарах хууль зүйн шаардлагууд эсвэл холбогдох хамтын гэрээтэй уялдуулан нөхөн олговор ба тэтгэмжүүдийг олгох ёстой.

Ажилчдын эрх, үүргийг багтаасан хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг тэдний эх хэл эсвэл ойлгодог хэлээр нь илэрхийлсэн хөдөлмөрийн гэрээ байгуулах ёстой.

Ажил амьдралын тэнцвэрийг эрүүлээр хангадаг, гэр бүлд ээлтэй ажиллах орчин нөхцөлийг хангах, боломжтой тохиолдолд гэмтэл бэртэлд өртсөн ажилчдыг эдгэрч, ажилдаа эргэн ороход туслах боломжийг бүрдүүлэхийг бэлтгэн нийлүүлэгчдэдээ уриалдаг.

ЗААВАРЧИЛГАА

Хууль ёсны ажлын цагийг баримталж, үнэн зөв баталгаажуулалтыг хийгээрэй.

Цалин хөлсний талаарх бүх бүртгэлийг үнэн зөвөөр хөтлөөрэй.

Илүү цагийн нөхөн олговор, ажилласан цаг, тэтгэмж, хууль ёсны суутгалууд, урамшуулал болон бусад холбогдох мэдээллийг багтаасан цалингийн задаргааг нэг бүрчлэн тодорхой харуулсан цалингийн хуудсаар бүх ажилтнуудыг хангаарай.

Ажилтнуудад тэдний хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлын талаар мэдэгдэж, жишээлбэл гарын үсэг зурсан хөдөлмөрийн гэрээний хуулбарыг хадгалаарай.

БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Зайлшгүй байх зүйлс:

- Өөрөөр зөвшилцсөнөөс бусад тохиолдолд ажлын бодит цагийг хэвийн ажлын цаг болон илүү цаг гэж хоёр хуваан бүртгэх.
- Ажилтнууд долоо хоногт хамгийн багадаа нэг өдөр амрах болон ээлжийн ажлын хооронд хангалттай амрах эрхтэй байх.
- Ажилтанд тухайн хугацаанд ажилласан цагийн хөлсийг зөвшилцсөн өдрөө бүрнээр, тогтмол, шууд төлөх.
- Гарын үсэг зурсан хөдөлмөрийн гэрээ ба цалингийн хуудсыг хянах.
- Ажилтнууд өвчний болон хүүхэд асрах чөлөө, баяр наадамын болон хууль ёсны амралтын хоногуудыг ямар нэг сөрөг үр дагаваргүйгээр авах эрхтэй байх.

4.6 ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ БОЛОН ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

Сэндвик нь эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон хууль ёсны дагуу тайван замаар эвлэлдэн нэгдэх, үйл ажиллагаа зохион байгуулах болон хамтын хэлэлцээр хийх эрхийг дэмждэг. Бид ажлын байрны оролцоог хөхүүлэн дэмжиж, идэвхжүүлэхийн тулд ажилтнуудтайгаа хамтран ажиллахыг бэлтгэн нийлүүлэгчдэдээ уриалдаг.

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Ажилтнуудынхаа хөдөлмөр эрхэлж буй улс орныхоо хууль тогтоомжийн дагуу чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, үйл ажиллагаа зохион байгуулах, хамтын хэлэлцээр хийх эрхийг бэлтгэн нийлүүлэгчид нь танин мэдэж, хүндэтгэх ёстой.

Ажилтнууд болон удирдлагын хоорондох нээлттэй харилцаа, шууд оролцооны ач холбогдлыг бэлтгэн нийлүүлэгчид нь танин мэдэж байх ёстой.

Ажилтнуудад хөдөлмөрийн асуудлаар бие даасан төлөөлөгч томилж, дарамт шахалт, сүрдүүлэг, шийтгэл, хөндлөнгийн оролцоо эсвэл заналхийлэлд өртөхөөс айхгүйгээр ажиллах орчин нөхцлийн талаар удирдлагатай нээлттэй харилцах боломжийг олгох ёстой.

Эсрэгээрээ, ажилчдын эвлэлд нэгдэхийг хүсэхгүй байгаа ажилтнуудын сонголтыг хүндэтгэх ёстой.

ЗААВАРЧИЛГАА

Боломжтой бол шаардлагагүй зөрчилдөөн үүсэхээс сэргийлэхийн тулд ажилтнууд болон удирдлагын хооронд харилцан ашигтай бүтээлч оролцоог дэмждэг ажиллах орчныг бий болгоорой.

Ажиллах орчин нөхцөлийн талаар ажилтнуудтай хамтран ажиллаж, хийгдсэн уулзалт эсвэл харилцаа холбооны талаарх бүртгэлийг хөтлөөрэй.

БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БҮЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Зайлшгүй байх зүйлс:

- Ажилтнууд үйл ажиллагаа зохион байгуулах болон хамтын хэлэлцээр хийх эрхтэй байх.
- Ажилтнууд хөдөлмөрийн асуудлаар бие даасан төлөөлөгч томилж, удирдлагатай харилцах эрхтэй байх.
- Ажилчдын төлөөлөгчдийг удирдлагаас мэддэг байх.
- Хамаарах тохиолдолд хамтын гэрээг хянан шалгах.
- Ажилчид болон удирдлагын хооронд хамтын ажиллагааны бүтэц ажиллаж байгаа эсэхийг нотлох.

4.7 ГАЗАР НУТАГ БОЛОН НӨӨЦ БАЯЛАГ ЭЗЭМШИХ, ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ АШИГЛАХ

Газар нутаг болон өмч хөрөнгө эзэмших эрх нь ядуурлыг зогсоож, орлого нэмэгдүүлж, хүйсийн тэгш байдлыг хангах, хүнсний аюулгүй байдал, энх тайван, аюулгүй байдалд хувь нэмэр оруулах чухал үүрэгтэй.

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Бэлтгэн нийлүүлэгчид нь өөрсдийн үйл ажиллагаа явуулдаг үл хөдлөх хөрөнгийн хууль ёсны, эрх бүхий эзэмшигч байх ёстой.

Бэлтгэн нийлүүлэгчид нь газар нутаг эсвэл нөөц баялаг эзэмших, албан шаардлагаар дахин суурьших, газар нутаг ашиглахад тавигдах хязгаарлалтаас урган гарах нийгэм, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, эдийн засгийн аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх ёстой.

Өмчийг албадан хураах эсвэл хүчээр нүүлгэн шилжүүлэх тохиолдолд хангалттай нөхөн төлбөр төлөхөөр хязгаарлагдахгүйгээр тухайн ажиллагаанд хамаарах хүмүүсийн амьдралын стандарт, амьжиргааг хадгалах зорилготойгоор арга хэмжээний төлөвлөгөөг ил тод байдлаар зөвшилцөн хэлэлцэх ёстой.

ЗААВАРЧИЛГАА

Өөрийн үйл ажиллагаа явуулдаг үл хөдлөх хөрөнгийн түрээс эсвэл газар эзэмших эрхийн нотолгоог хадгалж байгаарай.

Өөрийн үйл ажиллагаа явуулдаг үл хөдлөх хөрөнгийн түрээс эсвэл эзэмших эрхийг шилжүүлсэнээр өмнөх хэрэглэгчид эсвэл бусад хувьцаа эзэмшигчдэд нөлөөлж болзошгүй нөлөөлөл, компанийн тасралтгүй ажиллагаанаас шалтгаалан үүссэн нөлөөллийг үнэлээрэй. Хамгийн эмзэг ангиллуудад (хөдөө орон нутгийн иргэд, уугуул оршин суугчид, эмэгтэйчүүд ба хүүхдүүд) онцгой анхаарал тавиарай.

Хүмүүс бизнесийн үйл ажиллагаанд зай гаргахад зориулж нүүх эсвэл газар нутгаа өгөх шаардлагатай болсон тохиолдолд тухайн нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүсийн туйлын ашиг сонирхолд нийцсэн хамгийн тохиромжтой арга хэмжээг олох нээлттэй бөгөөд ил тод харилцаанд оролцоорой.

БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Зайлшгүй байх зүйлс:

- Газар эзэмших эрх эсвэл түрээсийн талаар хянан шалгах.
- Хамаарах тохиолдлуудад нөлөөллийн үнэлгээ ба/эсвэл урьдчилан тааварлаагүй нөхцөл байдлын төлөвлөгөөг хянан шалгах.
- Холбогдох тохиолдлуудад нөлөөлөлд өртсөн хувьцаа эзэмшигчидтэй зөвлөлдөн гаргасан арга хэмжээний төлөвлөгөөг хянан шалгах.

5 АШИГТ МАЛТМАЛ БА МЕТАЛИЙГ ХАРИУЦЛАГАТАЙГААР ОЛЖ АВАХ



Сэндвик нь бүх ашигт малтмалыг ёс зүйтэй аргаар олж авахыг дэмждэг. Сэндвик нь зөрчилдөөнд шууд эсвэл шууд бусаар хувь нэмрээ оруулдаг бэлтгэн нийлүүлэлтийн бизнесийн харилцаа эсвэл хүний эрхийн ноцтой зөрчлүүдийг хүлээн зөвшөөрдөггүй. Зөрчилдөөн үүссэн хэсгүүдэд хөндлөнгийн оролцоог нэвтрүүлэх нь тухайн уугуул хүн амд сөрөг үр дагавар учруулж болзошгүй тул Сэндвик нь эдгээр хэсгүүдээс ашигт малтмалыг ёс зүйтэй аргаар олж авахыг уриалдаг.

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Сэндвик компаний шууд бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээний нэг хэсэг болох тугалга, тантал, гянт, алт (3TG) кобальт агуулсан түүхий эд, бодис ханган нийлүүлэгчид:

- Ашигт малтмалыг хариуцлагатайгаар олж авах, зөрчил үүсгэхгүй байхтай холбоотойгоор бүх холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой.
- Зөрчилд өртсөн ба өндөр эрсдэлтэй хэсгүүдээс ашигт малтмалыг хариуцлагатайгаар бэлтгэн нийлүүлэх сүлжээнд тавигдах ЭЗХАХБ-ын (OECD) Магадлан шалгалтын удирдамж, зааврыг дагаж мөрдөх ёстой.
- 3TG ба кобальтын бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээний бүх оролцогчид хайлуулах эсвэл боловсруулах үйлдвэрийн түвшинд оролцдог байх.

Манай бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд байдаг 3TG хайлуулах болон боловсруулах үйлдвэрүүд нь хариуцлагатай ашигт малтмалын санаачлага (Responsible Minerals Initiative), хариуцлагатай хайлуулах үйлдвэрлэлийг баталгаажуулах үйл явц (RMAP) зэрэг гуравдагч этгээдийн хүлээн зөвшөөрсөн аудитын хөтөлбөрүүдээр үнэлэгдсэн байх ёстой.

Кобальт хайлуулах болон боловсруулах үйлдвэрүүд нь хөдлөнгийн үнэлгээ хийлгэсэн эсвэл хамгийн багадаа гуравдагч этгээдийн аудитын хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцдог байх ёстой.

Арилжааны нууцыг хадгалахын хажуугаар хариуцлагатай ашигт малтмалын санаачлагын зөрчилтэй ашигт малтмалуудыг тайлагнах загвар (CMRT) ба/эсвэл Кобальт тайлагнах загварыг (CRT) бөглөж, илгээх замаар өөрсдийн 3TG болон кобальт бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээгээ тайлагнах үүрэгтэй.

ЗААВАРЧИЛГАА

Түүхий эдийн үйлдвэрлэл болон зэвсэгт мөргөлдөөн эсвэл хүний эрхийн ноцтой зөрчлийн хоорондох холбоосын талаар ойлголттой байгаарай.


Ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээнд ямар албан тушаал эрхэлж буйгаасаа хамааран түүхий эдийг зөвхөн хариуцлагатай эх үүсвэрээс олж авахын тулд зүй ёсны арга хэмжээг авах, шаардлагатай үед өөрийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд хариуцлагатай эх үүсвэрийг ашиглахад нь нөлөөлөөрэй.

БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БҮЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

- ЭЗХАХБ-ын (OECD) Магадлан шалгалтын удирдамжтай уялдуулан магадлан шалгалтыг гүйцэтгэхэд хамтран ажиллахыг бид таниас хүлээдэг.
- Зүй ёсны гарал үүслийн Улсын Лавлагааны үр дүнг хянаарай.
- Ашигт малтмал ба металлийг хариуцлагатайгаар олж авах тухай тайлангаа хянаарай.
- Манай бэлтгэн нийлүүлэлтийн гинжин хэлхээн дэх хайлуулах болон боловсруулах үйлдвэрүүд нь ЕХ-ны Зөвлөлийн хариуцлагатай хайлуулах үйлдвэрийн жагсаалт, Хариуцлагатай ашигт малтмалыг баталгаажуулах үйл явц (RMAP)-н болзол хангасан хайлуулах үйлдвэрийн жагсаалтад багтсан эсвэл хамаарах тохиолдолд салбарын бусад адил схемээр зөвшөөрөгдсөн.

6 ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

Хүрээлэн буй орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах болон дахин боловсруулах системийг бий болгох нь Сэндвик компанид нэн чухал ач холбогдолтой. Бизнесийн ажиллагааны хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөллийг бууруулах ёстой бөгөөд хүрээлэн буй орчинг тасралтгүй нөхөн сэргээх замаар үйл ажиллагааг явуулах шаардлагатай. Үүнд биологийн төрөл зүйл, эко системийг хамгаалах, нөөцийн тогтвортой хэрэглээг дэмжих болон хариуцлагатайгаар газар өмчлөх, эзэмших ба ашиглах багтана.



ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Бэлтгэн нийлүүлэгчид нь өөрсдийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн ба үйлчилгээний хүрээлэн буй орчинд үзүүлж байгаа аливаа сөрөг нөлөөллийг багасгах эсвэл бууруулах эрсдэлд суурилсан арга замыг бий болгох, хэрэгжүүлэх ба хадгалах ёстой.

Бэлтгэн нийлүүлэгчийн тухайн үйлдэл хүрээлэн буй орчин эсвэл нийтийн эрүүл мэндэд хөнөөл учруулна гэж итгэж болохуйц шалтгаан байгаа үед урьдчилан сэргийлэх арга хэмжээг аль болох хурдан авах, өөрсдийн бүтээгдэхүүн, ажиллагаа, загвар болон материалын сонголтод хүрээлэн буй орчинд ээлтэй арга техникийг дэмжих ёстой.

Бэлтгэн нийлүүлэгчийн бизнес хүрээлэн буй орчинд хөнөөл учруулсан тохиолдолд урган гарах нийгэм, хүрээлэн буй орчин, эдийн засагт учирсан зардлыг төлөх шаардлагатай.

Бэлтгэн нийлүүлэгчид нь өөрсдийн бизнесийн ажиллагааны хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах үүднээс нэн ялангуяа дараах хэсгүүдэд өөрсдийн ажлыг хянах, хэмжих, баримтжуулах болон төлөвлөх шаардлагатай.

- Хүлэмжийн хийн (GHG) ялгарал
- Дахин боловсруулах систем
- Химийн бодис ба хортой бодисууд
- Хог хаягдал
- Агаар, ус ба хөрсөнд ялгарах бусад ялгарлууд
- Эрчим хүчний зарцуулалт
- Усны зарцуулалт

Сэндвик нь шинжлэх ухаанд суурилсан зорилтуудыг (Science Based Targets) дэмждэг Парисын гэрээтэй уялдуулан бэлтгэн нийлүүлэгчиддээ хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтууд тавихыг уриалдаг. Хүлэмжийн хийн ялгаралд мэдэгдэхгүйц нөлөөлдөг ханган нийлүүлэгчидтэй холбогдох мэдээллийг Сэндвикт өгөх шаардлагатай.

ЗААВАРЧИЛГАА

Бизнесийн үйл ажиллагаанаас үүсэх хүрээлэн буй орчны эрсдлийн үнэлгээг тогтмол явуулж, түүнээс сэргийлэх болон бууруулах бүтээмжийг үнэлээрэй.

Дахин боловсруулах систем руу шилжихэд оролцож, хязгаарлагдмал нөөцийг хадгалах чиглэлд ажиллаарай.

Хоёрдогч түүхий эд болох бүтээгдэхүүнийг тээвэрлэх, тухайн материалын талаар бүрэн мэдүүлэх замаар дахин боловсруулалтын тээвэрлэлт, зохицуулалтыг хангаарай.

Дахин ашиглах болон боловсруулах боломжтой материалууд ба нөөцийг сонгоорой.

Ялангуяа хортой хог хаягдал зэрэг газарт булах хог хаягдлыг багасгаарай.

Анхдагч түүхий эдээс 2догч түүхий эд хүртэлх амьдралын мөчлөг бүхий бүтээгдэхүүний хөгжилд хүрээлэн буй орчны асуудлыг багтаагаарай.

Хортой химийн бодисыг аюулгүй хувилбараар солихын тулд идэвхтэй ажиллаарай.

Эрчим хүч ба нөөцийн ашиглалтыг сайжруулахад идэвхтэй ажиллаарай.

Агаар бохирдол бага ялгаруулдаг эрчим хүчний эх үүсвэрийн нэмэгдүүлээрэй.

Олон улсын санаачлагуудыг дэмжих замаар хүрээлэн буй орчны хариуцлагаа өндөржүүлж, дэмжээрэй. Ялангуяа уур амьсгал ба нөөцийн үр ашигтай ашиглалт, дахин боловсруулалт болон олон улсын хүрээлэн буй орчны асуудлуудтай холбоотой зорилт ба гүйцэтгэлүүдийг олон нийтэд нээлттэй хүргээрэй.


БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Зайлшгүй байх зүйлс:

- Бизнесийн хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хүчин чармайлтыг нотлох.
- Бэлтгэн нийлүүлэгчийн бүтээгдэхүүнд ордог хортой, химийн бодис болон найрлагуудын талаарх мэдээллийг хянан шалгах.

7 БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ

Сэндвик нь өрсөлдөөний хуулийг хүндэтгэх, хувь хүний нууцлалын эрхийг хамгаалах болон гааль, экспортын хяналтын бүх дүрэм журмыг дагаж мөрдөх зэрэг бизнесээ ёс зүйн өндөр түвшинд эрхлэн явуулах үүрэг амлалт хүлээсэн билээ. Бид бэлтгэн нийлүүлэгчдээсээ мөн адилаар хүлээдэг.



7.1 АВИЛГЫН ЭСРЭГ

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Бэлтгэн нийлүүлэгчид нь орон нутгийн хууль тогтоомж ба авилгын эсрэг олон улсын конвенцуудыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд авилгын арга ажиллагааны аливаа төрөлд оролцох эсвэл Сэндвик компанийг үүнд оролцоход хүргэх ёсгүй.

Бэлтгэн нийлүүлэгчид нь Сэндвик компанийн ажилтнуудад эсвэл түүний туслан гүйцэтгэгч, төрийн албан тушаалтнууд зэрэг аливаа гуравдагч этгээдэд зүй бусаар нөлөөлөх зорилгоор үнэ бүхий ямар нэг зүйл санал болгох ёсгүй.

Бэлтгэн нийлүүлэгчид нь Сэндвик компаниатай хамтран ажиллах хугацаандаа ашиг сонирхлын болзошгүй аливаа зөрчлөөс зайлсхийж, зайлсхийх боломжгүй ашиг сонирхлын аливаа зөрчлийг Сэндвикт мэдэгдэх ёстой.

Бэлтгэн нийлүүлэгчид нь Сэндвик компанийн ханган нийлүүлэгчийн магадлан шалгалтын үйл явцад ил тод байдал гаргаж, шударга, шуурхай оролцох үүрэгтэй.

ЗААВАРЧИЛГАА

Тухайлбал авилгын эсрэг бодлогыг хэрэгжүүлэх, өөрсдийн ажилтнуудад холбогдох сургалтыг явуулах замаар авилгаас сэргийлэх үйл явцыг бий болгоорой.

БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Зайлшгүй байх зүйлс:

- Бодлого ба холбогдох харилцаа холбооны бүртгэл, сургалтын бүртгэл, бэлэг ба зугаа цэнгээний ажиллагааны бүртгэл, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянан шалгадаг.

7.2 ӨРСӨЛДӨӨНИЙ ХУУЛЬ

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Бэлтгэн нийлүүлэгчид нь шударга өрсөлдөөний зарчмыг эрхэмлэн гэрээний маягт ямар байхаас үл хамааран гэрээ хэлцэл хийхийн тулд хичээнгүй байж, мэргэжлийн өндөр түвшинг үргэлж баримтлах ёстой.

Бэлтгэн нийлүүлэгчид нь өрсөлдөөнөөс сэргийлэх, хязгаарлах зорилгоор эсвэл өрсөлдөөнөөс сэргийлэх, хязгаарлахад хүргэдэг албан болон албан бус аливаа гэрээ, хэлэлцээрийг батлах ёсгүй. Өрсөлдөөн эсвэл шударга арилжааг дэмжих хууль тогтоомжийг зөрчдөг гэрээ, хэлэлцээрийг батлах ёсгүй.

ЗААВАРЧИЛГАА

Холбогдох ажилтнуудад өрсөлдөөний хуулийн бодлогыг хүргээрэй.

Өрсөлдөөний хуулийн сургалтанд хамрагдсан ажилтнуудын бүртгэлийг хөтлөөрэй.

БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Зайлшгүй байх зүйлс:

- Шударга өрсөлдөөний бодлого ба дүрэм журмын хэрэгжилт болон холбогдох ажилтнуудын хамрагдсан сургалтыг баримтжуулах.

7.3 ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ХАМГААЛАЛТ

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Бэлтгэн нийлүүлэгчид нь хувийн мэдээллийн сангийн хамгаалалтын бүх холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөх, зөвхөн хууль ёсны бизнесийн зорилгыг биелүүлэхэд шаардлагатай үед хувийн мэдээллийг ашиглах ёстой.

ЗААВАРЧИЛГАА

Мэдээллийн сангийн нууцлалын журмууд:

- Хувь хүмүүст тэдний мэдээллийг хэзээ, яагаад ашигласан талаараа аль болох сайн мэдэгдэх.
- Өөрийн хууль ёсны, зүй ёсны зорилгыг биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай хувийн мэдээллийг ашиглах.
- Ийм зорилгыг биелүүлэхэд шаардлагатай болон хуулиар шаардсан хугацаанд хувийн мэдээллийг хадгалах.
- Өөрийн мэдэлд байгаа хувийн мэдээллийг холбогдох техникийн болон зохион байгуулалт, хамгаалалтын арга хэмжээг авах замаар хадгалах. Хэрэв хуулиар шаардсан бол хувийн мэдээллийн аливаа зөрчлийн талаар холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх.

БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БҮЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Зайлшгүй байх зүйлс:

- Танай байгууллага эдгээр мэдээллийн нууцлалын журмуудыг хэрэгжүүлж буйг харуулсан холбогдох бичиг баримтыг хянан шалгах.

7.4 АРИЛЖААНЫ ДҮРЭМ ЖУРМЫГ ДАГАЖ МӨРДӨХ

ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Бэлтгэн нийлүүлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнтэй холбоотой арилжааны үнэн зөв мэдээллийг хадгалж, хуваалцах ёстой.

Бэлтгэн нийлүүлэгчид нь дотоодын хууль тогтоомж болон олон улсын хориг, зохицуулалтыг даган мөрдөж, хоригийн зөрчлийн аливаа хэлбэрт оролцохгүй ба Сэндвик компанийг үүнд оролцоход хүргэх ёсгүй.

ЗААВАРЧИЛГАА

- Арилжааны дүрэм журмыг хэрэгжүүлж, өөрсдийн ажилтнуудыг холбогдох сургалтанд хамруулаарай.
- Өөрийн бүтээгдэхүүний талаарх холбогдох болон хүчинтэй дараах мэдээллийг хадгалж, илгээгээрэй: HS тарифын код, экспортын хяналтын ангиллын төлөв, чөлөөт худалдааны зорилгоор хөнгөлөлттэй ба хөнгөлөлттэй бус гарал үүслийн нэмэлт бичиг баримтууд болон танай бүтээгдэхүүн дэх US агууламж. Шаардлагатай бүртгэл ба нотолгоог хадгалаарай.

БИД ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨЖ БҮЙ ЭСЭХИЙГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ

Зайлшгүй байх зүйлс:

- Бэлтгэн нийлүүлэгчийн арилжааны дүрэм журмыг хянан шалгах.
- Хууль ёсны арилжааг эрхлэн явуулах үүднээс мэдээлэл ба бичиг баримт илгээхийг шаардах.
- Арилжааны мэдээлэл ба өгөгдсөн бусад мэдээллийн хүчинтэй байдлыг бататгах нотолгоог шаардах.

БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛ

Бэлтгэн нийлүүлэгчийн албан ёсны төлөөлөгчид болох Миний бие/Бид доор гарын үсэг зурсанаар, үүгээр Бэлтгэн нийлүүлэгч нь Бэлтгэн нийлүүлэгчийн дүрмийг хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөж буйг баталж байна.

Компанийн бүтэн нэр:

Байгууллагын регистрийн дугаар:

Хагя:

Огноо:

Нэр:

Албан тушаал:

Гарын үсэг:

Нэр:

Албан тушаал:

Гарын үсэг:

Компанийн тамга: